

БАТЛАВ:

ЗДТГ-ЫН ДАРГА

С.БОЛОРЖАРГАЛ

САЙХАН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ҮЙЛ  
АЖИЛЛАГААНД ДОТООД ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

**Нэг. Ерөнхийзүйл**

1.1 Энэхүү нийтлэг журмын зорилго нь байгууллагын хэмжээнд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулахтай холбогдуулж арилцааг зохицуулахад оршино.

1.2 Дотоод хяналт шалгалтыг зохион байгууллахдаа Монгол улсын төрийн хяналт шалгалтын тухай хууль, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам” болон энэхүү журмыг удирдлага болгоно.

**Хоёр. Дотоод хяналтшалгалтын зарчим, зорилго, хамраххүрээ**

2.1 Дотоод хяналт шалгалтны хууль дээдлэх, хараат бус, ил тод, шударга, бодитой, хөндлөнгийн аливаа нөлөөллөөс ангид байх зарчимд тулгуурлана.

2.2 Дотоод хяналт шалгалтын зорилго нь байгууллагын үйл ажиллагаа, нийтэд үзүүлж байгаа ажил үйлчилгээ нь Монгол Улсын хууль хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, эрх бүхий бусад байгууллага, албан тугщаалтны болон өөрийн гаргасан шийдвэрт нийцэж байгаа эсэхэд хяналт тавьж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэхэд чиглэнэ.

2.3 Дотоод хяналт шалгалтыг эрх бүхий албан тушаалтны баталсан удирдамж, төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж, байгууллагын үйл ажиллагааг бүрэн хамарсан байвал зохино.

**Гурав. Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нэгж, ажилтан,  
түүнийэрхүүрэг**

3.1 Байгууллагын даргын тушаалаар тухайн байгууллагын дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтныг томилон ажиллуулах бөгөөд тэдгээр нь төр захиргаа, хууль эрх зүйн болон санхүүгийн зохих мэдлэгтэй, байгууллаыгн үйл ажиллагааны чиглэлээр мэргэшсэн байвал зохино.

3.2 Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь байгууллагын удирдлагад шууд захирагдах бөгөөд зохион байгууллалтын хувьд бусад бүтэц, нэгжээс хараас бус байна.

3.3 Дотоод хяналт шалгалтын ажлын хэсэг нь байгууллагын даргын баталсан удирдамж, төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтыг гүйцэтгэнэ. Хяналт шалгалтын төлөвлөгөөг улиралаар хяналт шалгалт хийх тухай бүр боловсруулна.

3.4 Дотоод хяналт шалгалтын хэсэг нь хяналт шалгалтын дүн, авсан арга хэмжээний талаар хагас жилд нэгжээс доошгүй удаа байгууллагын хурлаар танилцуулна.

3.5 Тухайн байгууллагын удирдлага дотоод хяналтын нэгж, ажилтны ажил үүргийг ажлын байрны тодорхойлолтод тусгахын зэрэгцээ ажлын үр дүнг үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээг хийхдээ харгалзан үзэж, үр дүнгийн урамшуулал олгож болно.

#### **Дөрөв. Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтны эрх, үүрэг**

4.1 Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

4.1.1 Тусгайлан баталсан удирдамж, төлөвлөгөөний дагуу дотоод хяналт шалшалтыг гүйцэтгэж, дүнг тайлагнах;

4.1.2 Хяналт шалгалт явуулахдаа байгууллага, нэгжийн удирдлагатай шууд харилцаж, тэдгээрээс шаардлагатай мэдээ, судалгаа гаргуулах, холбогдох ажилтны ажлыг шалгаж танилцах, илэрсэн зөрчил, дутагдлын талаар тайлбар гаргуулах;

4.1.3 Илэрсэн зөрчил, дутагдлын шалтгаан нөхцөлийг тодруулан зөрчлийг арилгуулах, дахин гаргуулахгүй байх талаар арга хэмжээ авах;

4.1.4 Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, зөрчил гаргасан этгээдэд хариуцлага ногдуулах талаах байгууллагын удирдлагад санал тавтж шийдвэрлүүлэх;

4.1.5 Монгол Улсын хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, засгийн газрын шийдвэ, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актыг байгууллага болон харьяа байгууллагуудад сурталчилах, хэрэгжүүлэх талаар сургалт зохион байгуулах

4.1.6 Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөх хууль тогтоомж, дүрэм, журам, стандартыг боловсронгуй болгох талаар судалгаа, дүгнэлт гаргах

4.1.7 Дотоод хяналт шалгалтын үр нөлөө болон мэргэжлийн чадавхийг дээшлүүлэх зорилгоор хөндлөнгийн хяналтын байгууллагаас мэргэжил арга зүйн зөвлөгөө авах, зөрчлийг нь арилгаж чадахгүй асуудлыг хууль хяналтын эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, дүгнэлт гаргуулах, хамтран ажиллах талаар санал боловсруулан удирдлагад танилцуулж шийдвэрлүүлэх;

4.1.7. Хийсэн хяналт шалгалтын талаар бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх;

4.1.8. Дотоод хяналт шалгалтаар хүний амь нас, эрүүл мэнд, нийгэм болон хүрээлэн байгаа орчны аюулгүй байдалд шууд буюу шууд бусаар ноцтой аюул, хор хохирол учруулж болохуйц нөхцөл байдал үүссэн нь тогтоогдвол түүнийг арилгах арга хэмжээг нэн даруй авч, эрх бүхий байгууллагад мэдэгдэх;

4.1.9. Дотоод хяналт шалгалтын талаар зохион байгуулсан ажил, түүний үр дүнгийн тухай тайлан мэдээг орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллагад тайлагнах;

4.2. Дээрх эрх, үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дотоод хяналтын нэгж, ажилтанд аливаа дарамт, шахалт үзүүлэх, үйл ажиллагаанд нь хөндлөнгөөс нөлөөлөлхийг хориглоно.

#### **Дөрөв. Дотоод хяналт шалгалтын үйлажиллагаа**

4.1 Дотоод хяналт шалгалтыг дараахь чиглэлээр зохион байгуулна:

4.1.1 Ерөнхийлөгчийн зарлиг, УИХ, ЗГ-ийн тогтоол, албан даалгавар, төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, сумын ИТХ, засаг даргын шийдвэрийн биелэлт

4.1.2 Байгууллагын зүгээс иргэдэд үзүүлж байгаа ажил үйлчилгээний чанар, хүртээмж;

4.1.3 Ажлын байрны эрүүл ахуйн нөхцөл, хөдөлмөрийн аюулгүй байдлын холбогдох стандартын хэрэгжилт;

4.1.4 Байгууллагын ил тод байдлыг хангах шалгуур үзүүлэлтийн биелэлт;

4.1.5 Байгууллагын үйл ажиллагаанд ашиглаж байгаа автотээвэр, харилцаа холбоо, эрчим хүч, барилга байгуулламжийн аюулгүй байдал;

- 4.1.6 Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилт;
- 4.1.7 Байгууллагын нягтлан бodoх бүртгэлийн бодлогын баримт бичгийн боловсруулалт, мөрдөлт
- 4.1.7 Төсвийн гүйцэтгэл болон төсвийн ил тод байдалд тавих хяналт;
- 4.1.8 Өмч хөрөнгийн тооллого, бүртгэл, хадгалалт, ашиглалт, хамгаалалтыг шалгаж, зөрчил дутагдлыг шуурхай барагдуулах;
- 4.1.9 Дотоод хяналт шалгалтын удирдамж, төлөвлөгөөнд тусгагдсан бусад асуудал.

#### **Тав. Хариуцлагын талаар**

- 5.1. Дотоод хяналтын ажлын хэсгийн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг заавал арилгуулах бөгөөд зөрчил дутагдал давтан гаргасан буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомж, байгууллагын дотоод журамд заасан арга хэмжээг авна.
- 5.2. Дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал нь гэмтхэргийн шинжтэй бол асуудлыг хуулийн байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.

#### **ДОТООД ХЯНАЛТЫН АЖЛЫН ХЭСЭГ**